



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 18/18

Номгон

Аймгийн хэмжээнд 2020 оныг “Хүүхэд хамгаалалд эцэг эхийн үүрэг оролцоог хангуулах жил” болгон зарлах тухай

Аймгийн хэмжээнд 2019 оныг “Хүүхэд хамгаалал, өв тэгш хүмүүжлийн жил”-ийн ажлын тайланг хэлэлцэж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсэн ба хүүхэд хамгааллын бодлогын асуудлыг тухайн нэрлэсэн жилийн хүрээгээр хязгаарлах бус байнгын тасралтгүй хэрэгжүүлэх, улмаар аймгийн хэмжээнд статистик судалгаагаар хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн тоо, хүүхдүүдийн хорт зуршлын хэрэглээ нэмэгдсэн, хүчирхийлэлд өртөж байгаа хүүхдийн тоо өндөр байгаа, хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн үүрэг оролцоо хариуцлага сул, хүүхдийн хүмүүжилд бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зэрэг хандлагыг бий болгох, салбар дундын хамтыг ажиллагааг хөгжүүлэх зэрэг санал гарсныг ТЭМДЭГЛЭЭД :

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “е”, 19 дүгээр зүйлийн 19.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит ХҮИИ хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2020 оныг “Хүүхэд хамгаалалд эцэг эхийн үүрэг оролцоог хангуулах жил” болгон зарласугай.

2. “Хүүхэд хамгаалалд эцэг, эхийн үүрэг оролцоог хангуулах жил”-ийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны тусгай төлөвлөгөө батлан олон улсын төсөл хөтөлбөртэй уялдуулан төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлэж, тайланг хагас, бүтэн жилээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

1190040